



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 07 сарын 08 өдөр

Дугаар А/115

Бат-Өлзий сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дүгээр зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Засгийн газрын 2022 оны 02 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах тайлагнах журам”-ын 3.5.7, 3.6.1, 3.6.3, 3,6,7 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Байгаль хамгаалах сангийн зөвлөлийн 2022 оны 07 дугаар сарын 05-ний өдрийн 04 дүгээр хурлын шийдвэрийг үндэслэн ойн хортон шавьж устгах хорны зардалд 5,000,000 (таван сая) төгрөг, хортон шавьж устгах шатахууны зардалд 205,500 (хоёр зуун таван мянга таван зуун) төгрөг, сумын төвийн нийтийн хог цэвэрлэгээний хог тээвэрлэх шатахууны зардалд 94,800 (ерэн дөрвөн мянга найман зуун) төгрөг, хууль бус мод бэлтгэлээс урьдчилан сэргийлэх, тэмцэх ажлын хяналт шалгалтын шатахууны зардалд 1,168,500 (нэг сая нэг зуун жаран найман мянга таван зуун) төгрөг, нийт 6,468,800 (зургаан сая дөрвөн зуун жаран найман мянга найман зуун) төгрөгийг зарцуулсугай.

2. Зардалд шаардагдах 6,468,800 (зургаан сая дөрвөн зуун жаран найман мянга найман зуун) төгрөгийг Байгаль хамгаалах сангаас зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын Санхүүгийн албаны дарга (О.Отгонтуяа)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

С.АМГАЛАН